



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 8700

Арвайхээр

О.Очирсүхийг улсын асрамжийн
үйлчилгээнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.г, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн Хархорин сумын 3 дугаар багийн иргэн Осорын Очирсүх (УХ45070332) нь 74 настай, төрсөн үр хүүхэдгүй, харж хандах ах дүү байхгүй тул улсын асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2. Дээрх иргэнийг нийгмийн халамжийн асрамжийн үйлчилгээнд хамруулахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах, иргэнийг улсын асрамжид хүргүүлэхэд гарах зардлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (С.Ундрах)-т үүрэг болгосугай.



011101331

D:My Doc. Zahiramj. Zasag darga